



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2015/10



Monstat



ezStat

Статистикийн хэрэглэгч та бүхэн манай хэвлэмэл бүтээгдэхүүн болон тоо мэдээллүүдийг MONSTAT, ezStat аппликейшнуудээр дамжуулан Apple-ын iPhone, iPad төхөөрөмжтэй бол App store-с, андройд үйлдлийн системийн төхөөрөмжтэй бол Google play-с татан авч, суулгаж ашиглах боломжтой.



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

**10 сар
2015**

Баруун-Урт сум



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл.....	3
Аргачлалын тайлбар	4-5
Товч танилцуулга	6-12
Үндсэн үзүүлэлтүүд	13

I. Нийгмийн үзүүлэлт

I.1 Хөдөлмөр	14-16
I.2 Нийгмийн даатгал, нийгмийн халамж	17
I.3 Эрүүл мэнд	18-19
I.4 Гэмт хэрэг	20-21

II. Эдийн засгийн үзүүлэлт

II.1 Мөнгө, банк, даатгал	22
II.2 Төрийн санхүү	23-24
II.3 Үнэ	25-26
II.4 Хөдөө аж ахуй	27-28
II.5 Аж үйлдвэр	29-31



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэгээ:

Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухай сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-VI зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

...	Мэдээлэл байхгүй	x	Бүтцийн өөрчлөлт
0.0	Маш бага тоо	+, -	Зөрүү
-	Гүйцэтгэл байхгүй	*	Дахин

┌ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. 15-14 нь 2015 оны үзүүлэлтийн тухайн оны үзүүлэлтээс өсч, буурсан абсолют өөрчлөлт.

V. "Төл" нь төлөвлөгөө, "Гүйц" нь гүйцэтгэл.

VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Тэтгэвэр, тэтгэмж:** Уг мэдээг нийгмийн даатгал, халамж үйлчилгээний хэлтсүүд нь гарган нэгтгэж ирүүлдэг.
- **Эрүүл мэнд:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Соёл, урлаг:** Соёл, урлагийн үйл ажиллагааг эрхэлдэг газрууд нь мэдээг нэгтгэн гаргаж ирүүлдэг.
- **Газар өмчлөгч:** Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь сумдаас мэдээллийг авч нэгтгэн ирүүлсний дагуу мэдээллийг хүргэдэг.
- **Гэмт хэрэг:** Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатайгаар, болгоомжгүйгээ салах хэргийг нэгтгэн оруулсан.
- Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.



- Нийгмийн Аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
- 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Мөнгө, банк, даатгал:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг. Даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд үндсэн үйл ажиллагааны мэдээллийг гаргаж ирүүлдэг.
- **Төсөл:** Засгийн газрын зарим гол төслүүд болон сангуудын хөрөнгийн зээл олголт, үйл ажиллагааны мэдээллийг холбогдох хэлтэс, агентлагууд гаргаж ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг Санхүү төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ гэдэг нь** өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.
Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдол, тариалсан талбайн мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.
Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.
Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.
Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.
- **Тээвэр, холбоо:** Уг үйл ажиллагааг эрхэлдэг ААН-нэгжүүд болон сумдын тамгын газрууд мэдээг нэгтгэн гаргаж ирүүлдэг.



Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2015 оны эхний 10 сарын байдлаар)


I. Нийгмийн үзүүлэлт



I.1 Хүн ам

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2015 оны эхний 10 сарын байдлаар 1165 хүүхэд шинээр мэндэлж, 275 хүн нас баржээ. Хүн амын цэвэр өсөлт 890 болж 2014 оны мөн үеийнхээс 6.7 хувь буюу 56 хүнээр өслөө. 1000 хүнд ногдох төрөлт 20.5 нас баралт 4.8 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.3 пунктээр өсч, нас баралт 0.5 пунктээр буурсан байна.

Зураг.I.1.1 Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2011-2015 оны 10 сард




I.2 Хөдөлмөр

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2015 оны 10 дугаар сарын эцэст 937 болсон, үүний 405 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 880 нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оны мөн үеэс 19.9 хувь буюу 146 хүнээр, 2014 оны 12 дугаар сарын эцсээс 18.1 хувь буюу 135 хүнээр тус тус өссөн байна.

Эхний 10 дугаар сарын байдлаар хөдөлмөрийн хэлтэст 2148 иргэн шинээр бүртгүүлсний 644 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Зураг.I.2.1 Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд





Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 67.5 хувь нь 15-34 насны залуучууд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 19.8 хувь нь дээд, 2.3 хувь нь тусгай дунд, 5.0 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 57.0 хувь нь бүрэн дунд, 11.6 хувь нь суурь, 3.9 хувь нь бага боловсролтой, 0.4 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Зураг.1.2.2 Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшингээр, 10 дугаар сарын байдлаар



Эхний 10 дугаар сарын байдлаар 408 шинэ ажлын байр бий болсны дотор боловсруулах үйлдвэрийн салбарт 139 буюу 34.1 хувьтай байгаа нь хамгийн өндөр үзүүлэлтэй байна.



1.3 Нийгмийн халамж:

Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсээс эхний 10 дугаар сарын байдлаар нийт 4.4 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 18.7 мянган иргэнд олгосноос халамжийн сангаас 3.1 тэрбум төгрөгийг 12.0 мянган иргэнд, улсын төсвөөс 1.3 тэрбум төгрөгийг 6.7 мянган иргэнд тус тус олгожээ.



1.4 Эрүүл мэнд

Эхний 10 сарын байдлаар 212.7 мянган хүнд үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 19.2 хувь, 10.6 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь 0.9 хувь, урьдчилан сэргийлэх үзлэгт 68.6 мянган хүн хамрагдсан нь 30.5 хувиар тус тус буурсан байна.


Түргэн тусламжийн дуудлага 13.1 мянган удаа гарсны 3.6 мянга буюу 27.5 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн



тусламжийн дуудлага 13.8 хувиар, алсын дуудлага 10.0 хувиар тус тус буурсан байна.

Аймгийн хэмжээнд 2015 оны эхний 10 сард 1166 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 1165 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 35 буюу 3.1 хувиар, хүүхдийн тоо 33 буюу 2.9 хувиар тус тус өсчээ.

Зураг I.4.1 Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо



Нялхсын эндэгдэл аймгийн хэмжээнд 2015 оны эхний 10 сард 18 болж, өмнөх оны мөн үеэс 7 хүүхдээр буурч, харин 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 5 болж, өмнөх оны мөн үетэй адил түвшинд байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2015 оны энхий 10 сард 658 болж, өмнөх оны мөн үеэс 222 хүн буюу 50.9 хувиар өсөхөд цусан суулга 2.4 дахин, салхинцэцэг 7.5 дахин, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 20 буюу 37.0 хувиар, тэмбүү 30 буюу 26.1 хувиар, бусад өвчлөлөөр өвчлөгчдийн тоо 16 буюу 3.0 дахин өссөн нь голлон нөлөөлжээ.

Улаан бурхан өвчнөөр өвчлөгчид 92 болж өмнөх сараас 2.2 хувиар өссөн байна.



I.8 Гэмт хэрэг


Аймгийн хэмжээнд 2015 оны эхний 10 сард 280 гэмт хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 35 хүн нас барж, 136 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 3-аар буурчээ.

Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 836.2 сая төгрөгийн хохирол учирсны 81.3 хувийг нөхөн төлүүлсэн байна. Гэмт хэрэгт 310 хүн холбогдон сэжиглэгдсэний 27.9 хувь нь согтуугаар, 29.3 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлджээ.

Нийт 547 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеэс 1239 хүн буюу 69.4 хувиар буурсан байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 119 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна.



Зураг I.8.1 Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



II. Эдийн засгийн үзүүлэлт




II.1 Мөнгө, банк, даатгал

Монгол банкны мэдээгээр ХААН, Төрийн, Хас, Голомт, Капитал банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 99.7 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 4.1 тэрбум төгрөг буюу 4.3 хувиар, өмнөх оны мөн үеэс 2.4 тэрбум төгрөг буюу 2.5 хувиар тус тус өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 30.8 тэрбум төгрөг болж оны эхнээс 3.2 тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.1 тэрбум төгрөгөөр өсчээ.

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл 10 сарын эцэст 1.4 тэрбум болж өмнөх сараас 0.1 тэрбум төгрөгөөр өсч, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.4 хувийг эзэлж байна.

Зураг II.1.1 Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл, сарын эцэст, тэрбум төг




II.2 Төрийн санхүү:

Аймгийн төсвийн нийт орлого эхний 10 сард 37.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.5 тэрбум төгрөг буюу 8.6 хувиар, төсвийн зарлага санхүүжилт 36.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 5.8 тэрбум төгрөг буюу 13.7 хувиар тус тус буурчээ.



Аймгийн нэгдсэн төсвийн 13.8 хувийг татварын орлого, 4.9 хувийг татварын бус орлого, 0.1 хувийг хөрөнгө борлуулсны орлого, 81.2 хувийг тусламжийн орлого эзэлж байна.

Зураг. II.2.1 Төсвийн орлого, зарлага, тэрбум.төг




II.3 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2015 оны 10 дугаар сард өмнөх сараас 0.1 хувь, өмнөх оны мөн үеэс 6.3 хувь, жилийн эцсээс 4.5 хувиар өслөө.

Зураг II.3.1 Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар=100)





Хүснэгт II.3 Хэрэглээний үнийн индекс, 2015 оны 10 дугаар сар, бүлгийн дүнгээр


Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2015.X}{2014.X}$	$\frac{2015.X}{2014.XII}$	$\frac{2015.X}{2015.IX}$
Ерөнхий индекс	106.3	104.5	100.1
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	97.1	97.1	96.1
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	99.8	98.7	100.0
Хувцас, бөс бараа, гутал	103.5	102.0	101.4
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	149.2	132.2	107.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	103.7	101.1	99.5
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	100.5	99.7	99.0
Тээвэр	103.8	103.3	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.0	99.6	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	117.4	117.4	100.0
Боловсролын үйлчилгээ	132.5	132.5	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	111.5	109.1	100.0
Бусад бараа, үйлчилгээ	108.7	108.7	100.0

Ерөнхий индекс өмнөх сарынхаас 0.1 хувиар өсөхөд хувцас, бөс бараа, гутал 1.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш 7.0 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

**II.4 Хөдөө аж ахуй**

Газар тариалан. Ургац хураалтын мэдээгээр аймгийн хэмжээнд 10 дугаар сарын байдлаар 597.0 тн төмс, 226.0 тн хүнсний ногоо, 1.6 мян тн үр тариа, 180.7 тн тэжээлийн ургамал, 975.0 тн техникийн ургамал, 19.7 мян.тн өвс, 143 тн гар тэжээл, 2.1 мян.тн хужир, шүү бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс төмс 116 тн буюу 16.4 хувь, хүнсний ногоо 125.1 тн буюу 35.6 хувь, үр тариа 2.3 мян.тн буюу 41.1 хувь, тэжээлийн ургамал 26.3 тн буюу 12.7 хувь, техникийн ургамал 375 тн буюу 27.8 хувь, бэлтгэсэн гар тэжээл 102.5 тн буюу 41.7 хувиар тус тус буурч бэлтгэсэн өвс 6.8 мян.тн буюу 52.9 хувиар өссөн гүйцэтгэлтэй байна.

Зураг II.4.4 Ургац хураалт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар





II.5 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 20.4 тэрбум төгрөг болж өмнөх оноос 1.8 тэрбум төгрөг буюу 2.8 хувиар буурчээ. Ангиллаар нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл: боловсруулах аж үйлдвэрийнх 0.5 тэрбум төгрөг болж 2.6 хувиар өсч, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 14.8 тэрбум төгрөг болж 9.8 хувь, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 4.8 тэрбум төгрөг буюу 6.3 хувиар тус тус буурлаа.

Оны үнээр 109.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос 2.4 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс хүрэн нүүрс, цайрын баяжмал, цахилгаан, бялуу, тараг, хийжүүлсэн цэвэр ус, рашаан, хэвийн боов, ажлын хувцас, гэрийн бүрээс, дээлнээс бусад монгол хувцас, хүрэм, гэрийн бусад модон тавилга, сандал, ширмэн болон төмөх зуух, яндан, зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс өссөн байна.

СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

	Хэмжих нэгж	2013	2014	2015	Зөрүү	$\frac{2015}{2014}$ %
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд						
Төрсөн хүүхэд	хүн	1 032	1 132	1 165	33	102.9
Нялхасын эндэгдэл	хүн	17	25	18	- 7	72.0
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	888	734	880	146	119.9
Халдварт өвчнөөр өвчдөгчид	хүн	838	436	658	222	150.9
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	263	283	280	- 3	98.9
Хэрэгт холбогсод	хүн	267	272	310	38	114.0
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт						
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	108.3	109.5	104.5	- 5.0	95.4
Иргэдийн хадгаламж	сая.төг	25 806.7	28 679.4	30 785.1	2 105.7	107.3
Зээлийн өрийн үлдэгдэл	сая.төг	73 336.1	97 261.5	99 657.0	2 395.5	102.5
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	40 754.8	40 946.0	37 424.8	-3 521.2	91.4
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	34 284.9	42 345.0	36 535.1	-5 809.9	86.3
Тариалсан талбай: - Төмс	тн	709.8	713.6	597	- 117	
- Хүнсний ногоо	тн	272.7	351.0	226.0	- 488	31.7
- Үр тариа	тн	430.0	3 965.0	1 630.3	1 279	464.5
- Тэжээлийн ургамал	тн	40.4	207.0	180.7	- 26	87.3
- Техникийн ургамал	тн	20.0	1 350.0	975.0	- 375	72.2
Ургац хураалт, хадлан: - Өвс	тн	11 948.5	12 883.0	19 695.0	6 812	152.9
- Гар тэжээл	тн	657.5	245.5	143.0	- 103	58.2
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	25 592.5	22 172.4	20 359.2	-1 813.2	91.8
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая.төг	88 472.0	106 622.5	109 066.4	2 443.9	102.3

**I.1 ХӨДӨЛМӨР****I.1.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар**

Сум	2013.XII	2014.XII	2013.X	2014.X	2015.X	$\frac{2015.X}{2014.X}$ %
Асгат	14	33	12	31	13	41.9
Баяндэлгэр	37	46	57	54	28	51.9
Дарьганга	24	9	28	10	11	110.0
Мөнххаан	17	16	16	15	11	73.3
Наран	13	14	18	14	8	57.1
Онгон	25	39	32	37	17	45.9
Сүхбаатар	36	33	49	31	22	71.0
Түвшинширээ	14	32	21	19	32	168.4
Түмэнцогт	70	26	66	25	17	68.0
Уулбаян	26	12	40	16	5	31.3
Халзан	22	9	25	15	12	80.0
Эрдэнэцагаан	31	66	14	77	33	42.9
Баруун-Урт	434	410	510	390	671	172.1
Дүн	763	745	888	734	880	119.9

I.1.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр							Насны бүлгээр					
			Дээд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд боловсролтой	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
Асгат	13	5	2	-	1	8	2	-	-	2	6	1	4	-	-
Баяндэлгэр	28	19	2	-	2	16	4	4	-	11	10	4	2	1	-
Дарьганга	11	6	3	1	-	5	2	-	-	2	6	2	1	-	-
Мөнххаан	11	6	4	-	-	6	1	-	-	2	5	2	1	1	-
Наран	8	6	1	1	1	4	1	-	-	2	3	2	1	-	-
Онгон	17	7	3	-	-	11	2	1	-	4	3	6	3	1	-
Сүхбаатар	22	13	7	1	1	10	1	2	-	10	4	4	4	-	-
Түвшинширээ	32	14	2	3	2	15	7	3	-	8	7	10	4	3	-
Түмэнцогт	17	12	2	2	-	10	3	-	-	4	4	5	4	-	-
Уулбаян	5	3	-	-	-	4	-	1	-	1	2	-	-	-	2
Халзан	12	4	3	-	-	7	2	-	-	5	4	2	1	-	-
Эрдэнэцагаан	33	12	2	-	1	20	7	2	1	3	15	10	5	-	-
Баруун-Урт	671	268	111	16	32	422	63	21	6	164	307	124	67	9	-
Дүн	880	375	142	24	40	538	95	34	7	218	376	172	97	15	2



I.1.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сум	2013.I-XII	2014.I-XII	2013.I-X	2014.I-X	2015.I-X	$\frac{2015.I-X}{2014.I-X} \%$
Асгат	107	89	98	79	35	44.3
Баяндэлгэр	174	173	137	159	75	47.2
Дарьганга	110	42	88	38	20	52.6
Мөнххаан	69	57	58	48	52	108.3
Наран	83	37	64	32	42	131.3
Онгон	168	95	112	84	30	35.7
Сүхбаатар	110	134	72	122	57	46.7
Түвшинширээ	176	100	172	60	65	108.3
Түмэнцогт	108	89	69	80	36	45.0
Уулбаян	119	74	81	73	29	39.7
Халзан	104	74	75	62	34	54.8
Эрдэнэцагаан	74	233	54	209	116	55.5
Баруун-Урт	1 848	1 218	1 428	1 051	1 557	148.1
Дүн	3 250	2 415	2 508	2 097	2 148	102.4

I.1.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО, сумаар

Сум	2013.I-XII	2014.I-XII	2013.I-X	2014.I-X	2015.I-X	$\frac{2015.I-X}{2014.I-X} \%$
Асгат	75	46	75	45	18	40.0
Баяндэлгэр	98	88	83	80	39	48.8
Дарьганга	31	25	31	25	4	16.0
Мөнххаан	43	20	43	20	33	165.0
Наран	37	9	29	9	26	2.9*
Онгон	113	17	70	17	11	64.7
Сүхбаатар	29	95	20	89	26	29.2
Түвшинширээ	162	34	152	9	29	3.2*
Түмэнцогт	37	29	3	29	13	44.8
Уулбаян	82	53	62	52	12	23.1
Халзан	62	53	53	42	21	50.0
Эрдэнэцагаан	18	95	18	91	48	52.7
Баруун-Урт	977	478	905	456	364	79.8
Дүн	1 764	1 042	1 544	964	644	66.8



I.1.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Сум	Шинэ ажлын байранд орсон хүний тоо		Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаа									
			ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас агнуур	Боловсруулах үйлдвэр	Барилга	Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Боловсрол	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Урлаг, үзвэр, тоглоом наадам	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Бусад
	2014 I-X	2015 I-X										
Асгат	6	13	7	5	-	-	-	-	-	-	-	1
Баяндэлгэр	30	30	9	10	-	2	-	-	6	-	1	2
Дарьганга	9	13	3	5	2	-	-	-	-	-	1	2
Мөнххаан	51	15	11	2	-	-	-	-	-	-	2	-
Наран	15	12	2	5	-	3	-	-	-	-	-	2
Онгон	43	1	-	1	-	-	-	-	-	-	-	-
Сүхбаатар	38	11	7	1	-	-	-	-	2	-	-	1
Түвшинширээ	10	11	11	-	-	-	-	-	-	-	-	-
Түмэнцогт	64	6	-	3	-	1	-	-	-	1	-	1
Уулбаян	23	26	-	1	-	25	-	-	-	-	-	-
Халзан	4	5	3	2	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	80	45	11	20	2	6	-	-	1	1	3	1
Баруун-Урт	365	220	58	84	10	16	9	22	-	-	10	11
Дүн	738	408	122	139	14	53	9	22	9	2	17	21

**I.2 НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ****I.2.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая.төг**

Үзүүлэлт		2014.I-X		2015.I-X	
		Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Халамжийн сан	1 Халамжийн тэтгэвэр	1 606	1 636.3	1 307	1 536.3
	2 Халамжийн тэтгэмж	899	202.8	795	239.7
	Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд 1 удаа	844	136.4	716	137.6
	3 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд 1 удаа	9	1.3	1	0.1
	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	7	8.4	5	6.0
	Гэнэтийн аюулын улмаас орон гэргүй болсон өрхөд 1 удаа	15	18.0	62	74.4
	2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	8	16.0	7	14.0
	Нэг удаагийн тусламж	10	12.0	3	3.6
	Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	6	7.2	1	1.2
	3 Амжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	1 088	499.0	1 040	603.8
	Ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	570	210.7	570	289.9
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	236	106.7	215	116.2
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	119	55.8	105	57.0
	Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	30	16.1	18	11.0
	Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	16	8.4	11	6.1
	Хүүхэд, төрөл садангүй ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах	19	10.6	23	12.5
	16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	98	86.6	98	109.7
	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн	776	89.5	43	23.2
	4 халамжийн үйлчилгээ	542	123.0	4 137	232.1
	Ахмад настны нийгмийн хамгаалалын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт тусламж	542	123.0	4 137	232.1
	6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгогдож буй хөнгөлөлт, тусламж	373	160.9	370	92.5
	7 Хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал	-	-	4 297	400.9
Улсын төсвөөс	1 Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	1 483	547.3	1 560	562.4
	2 Алдар эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж	4 749	685.2	5 176	697.6
	3 Алдар цолтой ахмадуудад олгосон хөнгөлөлт тусламж	22	18.4	14	14.1
	ДҮН	11 528	4 147.5	18 739	4 416.5

**I.3 ЭРҮҮЛ МЭНД****I.3.1 ЭРҮҮЛ МЭНД**

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014.I-X	2015.I-X	Өсөлт	
				тоо	хувь
1. Нийт үзлэг	мян.хүн	263.4	212.7	-50.7	80.8
2. Ор хоног	мян.хүн	90.9	87.5	-3.4	96.3
3. Урьдчилан сэргийлэх үзлэг	мян.хүн	98.7	68.6	-30.1	69.5
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	10.7	10.6	-0.1	99.1
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	15.2	13.1	-2.1	86.2
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	4.0	3.6	-0.4	90.0
6. Осол гэмтлийн дуудлага	хүн	585	476	-109	81.4
7. Нийт нас баралт	хүн	298	275	-23	92.3
8. Амаржсан эх	хүн	1 131	1 166	35	103.1
Үүнээс: амьд төрсөн хүүхэд	хүн	1 132	1 165	33	102.9
9. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	25	18	-7	72.0
10. 1-5 хүртлэх насны эндсэн хүүхэд	хүн	5	5	-	100.0

I.3.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар

Сум	Амаржсан эх	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
Асгат	1	1	-	-
Баяндэлгэр	8	8	-	2
Дарьганга	2	2	-	-
Мөнххаан	6	6	-	-
Наран	-	-	-	-
Онгон	10	10	-	1
Сүхбаатар	5	5	-	-
Түвшинширээ	-	-	-	1
Түмэнцогт	1	1	1	-
Уулбаян	1	1	1	-
Халзан	-	-	-	-
Эрдэнэцагаан	29	28	-	-
Баруун-Урт	1 103	1 103	16	1
Дүн	1 166	1 165	18	5



I.3.3 ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ

Халдварт өвчин	Хэмжих нэгж	2014.I-X	2015.I-X	Өсөлт	
				тоо	хувь
Вируст гепатит	хүн	24	16	-8	66.7
Цусан суулга	хүн	11	26	15	236.4
Улаан бурхан	хүн	-	92	-	-
Бруцеллёз	хүн	16	17	1	106.3
Салхинцэцэг	хүн	12	90	78	7.5*
Сүрьеэ	хүн	54	74	20	137.0
Тэмбүү	хүн	115	145	30	126.1
Заг	хүн	118	112	-6	94.9
Трихоминиаз	хүн	78	62	-16	79.5
Бусад	хүн	8	24	16	3.0*
Бүгд		436	658	222	150.9

I.3.4 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

Сум	Халдвар өвчнөөр өвчлөгчид бүгд			Вируст гепатит	Цусан суулга	Бруцеллёз	Салхинцэцэг	Сүрьеэ	Тэмбүү	Заг	Трихоминиаз	Бусад
	2014.I-X	2015.I-X	1000 хүн тутамд									
Асгат	19	14	8.1	-	-	1	-	5	1	5	2	-
Баяндэлгэр	15	60	12.6	-	-	-	49	2	-	3	2	4
Дарьганга	17	5	1.7	-	-	-	-	2	2	-	1	-
Мөнххаан	12	39	8.9	-	-	1	-	9	1	3	1	24
Наран	3	13	8.5	-	-	2	-	1	3	5	1	1
Онгон	25	32	8.8	1	-	-	-	3	14	6	5	3
Сүхбаатар	35	28	8.9	-	-	-	-	3	14	2	8	1
Түвшинширээ	6	21	6.7	-	-	-	-	3	2	3	3	10
Түмэнцогт	5	7	3.0	-	-	-	-	3	-	1	2	1
Уулбаян	11	21	7.5	1	-	-	-	2	14	2	-	2
Халзан	19	13	8.1	-	-	1	-	2	7	1	2	-
Эрдэнэцагаан	41	58	8.9	2	-	4	-	14	23	9	5	1
Баруун-Урт	228	347	18.4	12	26	8	41	25	64	72	30	69
Дүн	436	658	11.5	16	26	17	90	74	145	112	62	116

**I.4 ГЭМТ ХЭРЭГ****I.4.1 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, төрлөөр**

Хэргийн төрөл	2013.I-X	2014.I-X	2015.I-X
Бүртгэгдсэн хэрэг-бүгд	263	283	280
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	88	94	89
Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	3	4	7
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	108	116	127
Бусдын эд хөрөнгийг хулгайлах	89	84	97
Үүнээс: Хувийн өмчийг хулгайлах	48	48	53
Малын хулгай	40	30	37
Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	4	7	4
Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх	6	19	16
Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	3	2	-
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	27	27	28
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	-	1
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал,	23	29	21
Бусад гэмт хэрэг	14	11	7
Гэмт хэргийн улмаас учирсан хохирол			
Гэмтэж осолдсон хүн	110	126	136
Нас барсан хүн	28	36	35
Нийт хохирол /сая төгрөг/	463.8	417.8	836.2
Нөхөн төлүүлсэн хохирол /хувь/	77.0	78.3	81.3

I.4.2 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, сумаар

Сум	2013.I-X	2014.I-X	2015.I-X
Асгат	8	9	8
Баяндэлгэр	7	7	8
Дарьганга	9	8	10
Мөнххаан	22	19	18
Наран	6	5	6
Онгон	5	7	7
Сүхбаатар	16	15	22
Түвшинширээ	8	1	13
Түмэнцогт	15	6	8
Уулбаян	8	12	5
Халзан	5	3	7
Эрдэнэцагаан	35	43	28
Баруун-Урт	119	148	140
Дүн	263	283	280



I.4.3 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО

Сэжигтэн, яллагдагчийн тоо	2013.I-X	2014.I-X	2015.I-X
Бүгд	267	272	310
Үйлдэхдээ:			
-Бүлэглэсэн	66	74	82
-Согтуу байсан	91	86	78
Урьд ял шийтгэгдсэн	2	3	3
Эрүүлжигдсэн	2 426	1 786	547
Үүнээс: Баривчлуулсан хүн	248	208	119

I.4.4 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО, сумаар

Сум	2013.I-X	2014.I-X	2015.I-X
Асгат	6	9	6
Баяндэлгэр	6	8	8
Дарьганга	9	5	9
Мөнххаан	28	18	21
Наран	6	4	5
Онгон	4	7	6
Сүхбаатар	17	14	17
Түвшинширээ	11	-	8
Түмэнцогт	18	4	7
Уулбаян	9	11	6
Халзан	4	1	5
Эрдэнэцагаан	39	42	21
Баруун-Урт	110	149	191
Дүн	267	272	310

**II.1 МӨНГӨ, БАНК, ДААТГАЛ****II.1.1 ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, банкуудаар, сарын эцэст, сая.төг**

Банк	Зээлийн өрийн үлдэгдэл			Хадгаламжийн үлдэгдэл		
	2014.XII	2014.X	2015.X	2014.XII	2014.X	2015.X
ХААН	58 300.3	58 949.1	63 583.1	17 498.6	13 587.9	14 298.0
ХАС	4 423.5	4 253.0	4 902.1	3 914.6	3 826.0	3 795.2
Голомт	5 835.0	7 037.6	4 910.5	1 195.4	1 153.7	1 082.5
Төрийн банк	26 535.0	26 671.1	25 186.2	11 344.8	10 073.6	11 412.9
Капитал	420.2	350.7	1 075.1	66.8	38.2	196.5
Дүн	95 514.0	97 261.5	99 657.0	34 020.2	28 679.4	30 785.1

II.1.2 ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, тооцооны төвүүдээр, сая.төг

Сум	Зээлийн өрийн үлдэгдэл			Хадгаламжийн үлдэгдэл		
	2014.XII	2014.X	2015.X	2014.XII	2014.X	2015.X
Асгат	1 311.6	1 352.6	1 776.2	1 117.4	1 018.7	1 137.7
Баяндэлгэр	3 649.3	3 682.6	4 903.4	2 477.9	2 221.0	2 233.0
Дарьганга	2 079.2	2 156.2	2 348.6	2 120.3	1 882.4	1 948.7
Мөнххаан	4 382.9	4 502.9	5 091.2	1 662.4	1 601.0	1 587.1
Наран	1 606.9	1 632.3	2 040.7	1 076.9	932.4	1 122.1
Онгон	4 638.5	4 723.5	5 339.7	2 514.3	1 970.7	2 032.3
Сүхбаатар	3 674.5	3 894.7	4 140.7	1 057.6	819.7	1 195.0
Түвшинширээ	2 870.8	2 931.3	3 453.5	840.1	742.6	766.4
Түмэнцогт	2 569.7	2 645.4	2 288.2	1 504.3	1 325.7	1 348.7
Уулбаян	3 361.5	3 598.1	4 171.0	808.5	731.2	826.2
Халзан	1 314.9	1 346.2	1 660.0	690.1	589.9	772.1
Эрдэнэцагаан	7 765.3	7 744.1	8 351.6	1 631.3	1 600.6	1 689.3
Баруун-Урт	8 675.2	8 919.4	8 158.1	2 929.2	2 215.3	2 704.3
Бичигт	372.9	346.1	277.2	100.6	84.8	165.2
Төмөртэй	1 629.7	1 618.3	1 736.1	133.2	121.3	247.9
Салбар	45 611.1	46 167.8	43 920.8	13 356.1	10 822.1	11 009.1
Дүн	95 514.0	97 261.5	99 657.0	34 020.2	28 679.4	30 785.1

**II.2 ТӨРИЙН САНХҮҮ****II.2.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая.төг**

	2014.I-X	2015.I-X			$\frac{2015.I-X}{2014.I-X} \%$
		Төл	Гүйц	%	
А. Урсгал орлого	8 621.5	6 969.2	7 033.4	100.9	81.6
1. Татварын орлого	4 651.9	5 794.3	5 159.1	89.0	110.9
1.1 Орлогын албан татвар	3 532.8	4 029.3	3 785.8	94.0	107.2
1.2 Өмчийн татвар	371.2	465.9	310.3	66.6	83.6
1.3 Дотоодын бараа үйлчилгээний татвар	279.6	356.0	293.4	82.4	104.9
1.4 Бусад	849.5	943.1	1 247.8	132.3	146.9
2. Татварын бус орлого	3 149.5	867.2	1 824.6	210.4	57.9
3. Хөрөнгө борлуулсны орлого	820.1	307.7	49.7	16.2	6.1
Б. Тусламжийн орлого	32 324.5	34 283.8	30 391.4	88.6	94.0
Нийт орлого ба тусламжийн дүн	40 946.0	41 253.0	37 424.8	90.7	91.4

II.2.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая.төг

	2014.I-X	2015.I-X			$\frac{2015.I-X}{2014.I-X} \%$
		Төл	Гүйц	%	
1. Урсгал зардал	42 345.0	40 270.3	36 535.1	90.7	86.3
1.1 Цалин хөлс ба нэмэгдэл урамшил	14 899.7	16 979.1	16 173.2	95.3	108.5
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1 573.1	1 853.3	1 728.9	93.3	109.9
1.3 Байр ашиглалттай холбоотой зардал	1 694.1	2 912.8	2 962.9	101.7	174.9
1.4 Хангамжийн бараа материал	715.9	573.4	536.4	93.5	74.9
1.5 Нормативт зардал	1 286.7	1 754.7	1 501.8	85.6	116.7
1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	480.7	189.3	240.8	127.2	50.1
1.7 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	685.3	4 742.2	805.3	17.0	117.5
1.8 Томилот зочны зардал	182.9	182.3	118.6	65.1	64.8
1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	1 652.6	1 761.9	3 281.8	186.3	198.6
1.10 Нийгмийн халамж үйлчилгээний зардал	3 585.4	4 657.2	4 073.1	87.5	113.6
1.11 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1 341.3	482.6	331.2	68.6	24.7
1.12 Төрөөс иргэдэд үзүүлсэн бусад тэтгэмж, дэмжлэг	314.5	-	-	-	-
1.13 Хөрөнгө оруулалт	13 931.2	4 181.5	4 604.8	110.1	33.1
1.14 Татаас	-	-	176.3	-	-
1.14 Их засвар	1.6	-	-	-	-
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	42 345.0	40 270.3	36 535.1	90.7	86.3



II.2.3 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сумаар, сая.төг

Сум	Орлого				ХАОАТ		АТБӨЯХ-ийн татвар		Газрын төлбөр	
	2014.I-X	2015.I-X			Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
		Төл	Гүйц	%						
Асгат	60.6	69.5	71.7	103.2	57.3	53.1	7.0	6.2	0.5	0.6
Баяндэлгэр	155.8	174.6	165.7	94.9	144.5	135.2	18	24.2	0.3	0.3
Дарьганга	85.3	120.6	97.6	80.9	99.9	76.2	11.0	13.0	0.4	0.4
Мөнххаан	163.1	153.1	132.7	86.7	121.8	98.7	19.0	22.2	2.1	0.3
Наран	70.3	72.3	84.7	117.2	61.1	67.3	8.0	8.7	0.8	0.4
Онгон	250.2	306.6	286.8	93.5	274.4	256.9	16.0	15.6	0.7	0.8
Сүхбаатар	113.4	119.9	116.1	96.8	87.4	80.2	10.5	10.6	19.0	13.8
Түвшинширээ	95.2	107.4	100.9	93.9	88.6	78.3	13.0	15.3	1.1	0.8
Түмэнцогт	117.3	112.4	980.2	872.1	91.2	86.7	11.0	11.9	4.5	4.5
Уулбаян	62.1	148.6	156.9	105.6	111.5	95.2	10.0	8.1	15.0	20.5
Халзан	387.2	76.1	88.6	116.4	64.6	62.3	7.0	6.3	0.4	0.3
Эрдэнэцагаан	285.3	428.3	433.3	101.2	360.9	329.3	27.0	31.1	8.5	4.2
Баруун-Урт	2 919.1	2 465.4	3 013.5	122.2	2 201.4	2 399.3	-	120.2	-	6.9
Сумын дүн	4 764.9	4 354.8	5 728.7	131.5	3 764.6	3 818.7	157.5	293.4	53.3	53.8
Аймгийн дүн	40 946.0	41 253.0	37 424.8	90.7	4 029.3	3 818.7	356.0	293.4	148.5	53.8

Тайлбар: Аймгийн Татварын хэлтсийн 10-р сарын мэдээгээр

II.2.4 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сумаар, сая.төг

Сум	Зарлага				Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал		Хангамж бараа материалын зардал	
	2014.I-X	2015.I-X			Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
		Төл	Гүйц	%						
Асгат	1 140.9	1 129.1	904.4	80.1	643.8	618.3	179.0	9.6	26.3	21.9
Баяндэлгэр	1 969.8	1 964.4	1 779.8	90.6	1 191.8	1 123.5	214.5	1.2	35.0	52.3
Дарьганга	1 415.2	1 420.3	1 176.2	82.8	842.0	778.0	200.2	3.4	29.8	25.5
Мөнххаан	1 886.8	1 738.6	1 581.8	91.0	1 098.6	1 039.1	183.4	1.9	30.9	25.2
Наран	1 177.7	1 157.1	920.5	79.6	690.1	618.2	176.7	2.9	24.1	20.9
Онгон	1 535.7	1 364.6	1 087.0	79.7	805.2	759.3	199.1	2.7	17.2	20.3
Сүхбаатар	1 546.0	1 440.0	1 192.7	82.8	849.0	779.4	195.4	2.5	26.7	24.3
Түвшинширээ	1 398.9	1 440.4	1 276.6	88.6	886.1	804.6	154.8	2.6	26.3	21.6
Түмэнцогт	1 568.6	2 211.7	1 665.3	75.3	811.2	797.0	989.9	3.6	24.2	22.4
Уулбаян	1 193.3	1 239.6	1 071.2	86.4	761.7	738.9	147.4	1.6	25.4	22.7
Халзан	2 410.9	1 121.1	1 101.7	98.3	641.5	655.9	217.6	1.6	19.3	20.8
Эрдэнэцагаан	2 233.8	2 258.1	1 973.2	87.4	1 363.1	1 370.7	262.1	2.1	53.1	46.7
Баруун-Урт	7 391.4	7 596.5	7 693.2	101.3	4 305.3	4 186.8	514.2	43.6	66.5	63.8
Сумын дүн	26 869.0	26 081.5	23 423.6	89.8	14 889.4	14 269.7	3 634.3	79.3	404.8	388.4
Аймгийн дүн	42 345.0	40 270.3	36 535.1	90.7	16 979.1	16 173.2	4 742.2	805.3	573.4	536.4

**II.3 ҮНЭ****II.3.1 ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС**

Барааны бүлгээр	$\frac{2015.X}{2014.X}$	$\frac{2015.X}{2014.XII}$	$\frac{2015.X}{2015.IX}$
ЕРӨНХИЙ ИНДЕКС	106.3	104.5	100.1
ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	97.1	97.1	96.1
Хүнсний бараа	96.5	96.8	95.7
Талх, гурил, будаа	103.8	103.4	99.2
Мах, махан бүтээгдэхүүн	79.4	85.6	89.2
Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг	97.7	87.6	103.2
Төрөл бүрийн өөх, тос	99.2	99.2	95.2
Жимс, жимсгэнэ	102.3	108.0	86.0
Төмс, хүнсний ногоо	101.7	95.0	89.3
Саахар, жимсний чанамал, чихэр, шоколад	95.1	93.7	98.0
Хүнсний бусад бүтээгдэхүүн	99.7	99.3	100.3
Согтууруулах бус ундаа	102.6	100.5	100.1
СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	99.8	98.7	100.0
Согтууруулах ундаа	102.3	100.4	100.0
Тамхи	98.3	97.5	100.0
ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	103.5	102.0	101.4
Хувцас, бөс бараа	102.8	101.5	101.5
Хөвөн бөс, бараа	96.2	100.0	100.0
Бүх төрлийн хувцас	102.9	101.4	101.6
Жижиг эдлэл, хэрэгсэл	107.1	106.7	99.8
Гутал	105.7	103.4	101.0
ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	149.2	132.2	107.0
Орон сууцны бодит түрээс	113.3	113.3	113.3
Орон сууцны засвар, үйлчилгээ	104.9	100.0	100.0
Усан хангамж, бусад үйлчилгээ	138.3	138.3	100.0
Цахилгаан, хийн болон бусад түлш	201.8	162.4	112.2
ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	103.7	101.1	99.5
Тавилга, хэрэгсэл, хивс, дэвсгэр	102.4	100.5	100.0
Оёмол, нэхмэл эдлэл	103.7	98.3	97.4
Цахилгаан бараа	101.3	101.4	100.0
Шилэн эдлэл, сав суулга	116.4	102.9	100.0
Багаж хэрэгсэл	106.9	103.3	100.0
Цэвэрлэгээний болон бусад жижиг бараа	102.8	101.8	99.4
ЭМ, ТАРИА, ЭМНЭЛЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.5	99.7	99.0
Эм, тариа, эмнэлэгийн хэрэгсэл	100.5	99.6	98.5
Амбулаторийн үйлчилгээ	103.1	100.0	100.0
Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх үйлчилгээ	100.0	100.0	100.0
ТЭЭВЭР	103.8	103.3	100.0
Тээврийн хэрэгслийн худалдан авалт	108.0	108.0	100.0
Хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ	100.6	100.6	100.0
Тээврийн үйлчилгээ	103.9	100.0	100.0
ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	99.0	99.6	100.0
АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	117.4	117.4	100.0
Дуу, дүрс, гэрэл зураг, бусад тоног төхөөрөмж	109.2	109.3	100.0
Чөлөөт цаг, соёлын үйлчилгээ	138.8	138.8	100.1
Ном, сонин бичгийн хэрэгсэл	107.6	107.6	100.0
БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	132.5	132.5	100.0
ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	111.5	109.1	100.0
Нийтийн хоолны үйлчилгээ	106.5	106.5	100.0
Зочид буудал, дотуур байрны үйлчилгээ	118.4	112.5	100.0
БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	108.7	108.7	100.0
Хувь хүнд хандсан үйлчилгээ	110.5	110.5	100.0
Хувь хүний эд зүйл, хэрэглэл	98.9	98.9	100.0
Санхүүгийн үйлчилгээ	100.0	100.0	100.0



II.3.2 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны үнэ

Нэр төрөл	2013.X	2014.X	2015.X	$\frac{2015.X}{2014.X} \%$
1-р зэргийн гурил, кг	920	1 250	1 300	104.0
Хонины мах, кг	5 800	6 000	4 750	79.2
Үхрийн мах, кг	6 300	7 050	5 875	83.3
Ямааны ястай мах, кг	4 500	5 050	3 625	71.8
Элсэн чихэр, кг	1 570	1 642	1 616	98.4
Цагаан будаа, кг	2 136	2 182	2 198	100.7
Шингэн сүү, л	1 080	1 220	1 175	96.3
Цагаан ноолуур, кг	46 000	50 000	40 000	80.0
Бор ноолуур, кг	46 000	50 000	40 000	80.0
Бензин, А-80, 1 литр	1 640	1 660	1 660	100.0
Бензин, А-92, 1 литр	1 880	1 920	1 920	100.0
Дизелийн түлш, литр	1 910	1 950	1 950	100.0

II.3.3 ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

Нэр төрөл	2013.X	2014.X	2015.X	$\frac{2015.X}{2014.X} \%$
Хонины ноос	300	150	150	100.0
Адууны дэл	2 000	4 000	6 000	150.0
Адууны сүүл	6 000	5 500	7 500	136.4
Адууны шир	29 000	30 000	28 000	93.3
Үхрийн шир 1.8-2.3 метрийн хэмжээтэй	22 500	32 500	25 000	76.9
Үхрийн шир 2.3 метрээс дээш хэмжээтэй	32 500	40 000	37 500	93.8
Хонины ноостой нэхий	6 000	4 000	500	12.5
Ямааны ноолууртай арьс	10 500	9 000	4 500	50.0
Сонгино	1 250	1 100	1 150	104.5
Сармис	3 500	3 250	3 500	107.7
Өргөст хэмх	2 250	3 000	3 550	118.3
Улаан лооль	2 750	3 450	4 000	115.9
Тарвас	2 400	1 500	1 500	100.0
Өндөг	-	375	315	84.0

**II.4 ХӨДӨӨ АЖ АХУЙ****II.4.1 УРГАЦ ХУРААЛТ, ХАДЛАН, ТЭЖЭЭЛ БЭЛТГЭЛТ. сумаар, тонн**

Сум	Үр тариа		2015.I-X	Тэжээлийн ургамал		2015.I-X
	2014.I-X	2015.I-X	2014.I-X	2014.I-X	2015.I-X	2014.I-X
Асгат	-	1.3	-	-	0.7	-
Баяндэлгэр	-	-	-	-	-	-
Дарьганга	-	-	-	-	-	-
Мөнххаан	150.0	-	-	-	-	-
Наран	-	-	-	-	-	-
Онгон	-	-	-	-	-	-
Сүхбаатар	2 560.0	604.0	23.59	207.0	180.0	86.96
Түвшинширээ	-	-	-	-	-	-
Түмэнцогт	1 255.0	275.0	21.91	-	-	-
Уулбаян	-	-	-	-	-	-
Халзан	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	-	750.0	-	-	-	-
Баруун-Урт	-	-	-	-	-	-
Бүгд	3 965.0	1 630.3	41.12	207.0	180.7	87.29

II.4.2 үргэлжлэл

Сум	Техникийн ургамал		2015.I-X	Бэлтгэсэн өвс		Үүнээс өөр харьяат иргэн бэлтгэсэн өвс	2015.I-X
	2014.I-X	2015.I-X	2014.I-X	2014.I-X	2015.I-X		2014.I-X
Асгат	-	-	-	198.0	1 830.0	1 680.0	9.2*
Баяндэлгэр	-	-	-	10.0	-	-	-
Дарьганга	-	-	-	750.0	810.0	-	108.0
Мөнххаан	200.0	5.0	2.5	800.0	2 100.0	1 300.0	2.6*
Наран	-	-	-	430.0	400.0	-	93.0
Онгон	-	-	-	200.0	360.0	-	180.0
Сүхбаатар	750.0	-	-	580.0	700.0	-	120.7
Түвшинширээ	-	-	-	84.0	1 500.0	-	17.9*
Түмэнцогт	400.0	220.0	55.0	4 761.0	4 850.0	700.0	101.9
Уулбаян	-	-	-	-	-	-	-
Халзан	-	-	-	45.0	45.0	-	100.0
Эрдэнэцагаан	-	-	-	865.0	1 190.0	-	137.6
Баруун-Урт	-	750.0	-	4 160.0	5 910.0	-	142.1
Бүгд	1 350.0	975.0	72.2	12 883.0	19 695.0	3 680.0	152.9



II.4.2 үргэлжлэл

Сум	Бэлтгэсэн гар тэжээл		2015.I-X	Бэлтгэсэн хужир шүү		2015.I-X
	2014.I-X	2015.I-X	2014.I-X	2014.I-X	2015.I-X	2014.I-X
Асгат	4.0	-	-	3.1	-	-
Баяндэлгэр	4.0	-	-	6.0	5.9	98.3
Дарьганга	-	-	-	-	-	-
Мөнххаан	30.0	30.0	-	-	-	-
Наран	30.0	35.0	116.7	-	-	-
Онгон	-	-	-	125.0	-	-
Сүхбаатар	50.0	50.0	100.0	-	-	-
Түвшинширээ	76.5	-	-	-	-	-
Түмэнцогт	10.0	-	-	-	-	-
Уулбаян	-	-	-	-	-	-
Халзан	19.0	13.0	-	-	240.0	-
Эрдэнэцагаан	2.0	5.0	250.0	842.0	1 280.0	152.0
Баруун-Урт	20.0	10.0	50.0	320.0	600.0	187.5
Бүгд	245.5	143.0	58.2	1 296.1	2 125.9	164.0

II.4.2 үргэлжлэл

Сум	Төмс		2015.I-X	Хүнсний ногоо		2015.I-X
	2014.I-X	2015.I-X	2014.I-X	2014.I-X	2015.I-X	2014.I-X
Асгат	18.4	6.3	34.2	6.5	4.4	67.4
Баяндэлгэр	10.0	13.0	130.0	4.6	0.1	3.2
Дарьганга	14.5	24.5	169.0	8.7	9.8	112.6
Мөнххаан	48.0	45.0	93.8	15.5	17.0	109.7
Наран	5.8	11.0	189.7	4.2	8.1	192.9
Онгон	54.0	45.0	83.3	5.1	3.5	68.6
Сүхбаатар	48.0	24.0	50.0	16.1	6.0	37.3
Түвшинширээ	29.9	7.8	26.1	29.6	7.7	26.0
Түмэнцогт	56.0	48.0	85.7	32.7	31.2	95.4
Уулбаян	27.3	26.8	98.2	6.9	6.9	99.9
Халзан	10.7	0.7	6.5	2.7	0.6	21.1
Эрдэнэцагаан	45.5	46.0	101.1	18.5	6.8	36.8
Баруун-Урт	345.5	298.9	86.5	200.0	123.9	62.0
Бүгд	713.6	597.0	83.7	351.1	226.0	64.4

**II.5 АЖ ҮЙЛДВЭР****II.5.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая.төг**

Аж үйлдвэрийн салбар	2014.I-X	2015.I-X	Дүнд эзлэх хувь	
			2014.I-X	2015.I-X
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	16 390.5	14 778.7	73.9	72.6
Нүүрс	321.8	687.0	1.5	3.4
Цайрын баяжмал	15 991.9	14 074.8	72.1	69.1
Хайрга	76.8	16.9	0.3	0.1
Боловсруулах аж үйлдвэр	455.5	467.1	2.1	2.3
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт	260.7	273.8	1.2	1.3
Дээрхи ангид ороогүй бусад үйлдвэрлэл	194.8	193.2	0.9	0.9
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	5 326.4	5 113.4	24.0	25.1
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	5 180.3	4 854.2	23.4	23.8
Ус хуримтлуулах, ариутгах, усан хангамжийн үйл ажиллагаа	146.1	259.3	0.7	1.3
Дүн	22 172.4	20 359.2	100.0	100.0

II.5.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, оны үнээр, сая.төг

Аж үйлдвэрийн салбар	2014.I-X	2015.I-X	Дүнд эзлэх хувь	
			2014.I-X	2015.I-X
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	97 921.0	99 946.2	91.8	91.6
Нүүрс	902.8	2 547.5	0.8	2.3
Цайрын баяжмал	96 474.5	97 287.9	90.5	89.2
Хайрга	543.7	110.8	0.5	0.1
Боловсруулах аж үйлдвэр	4 279.3	2 305.9	4.0	2.1
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт	875.0	816.4	0.8	0.7
Дээрхи ангид ороогүй бусад үйлдвэрлэл	3 404.3	1 489.5	3.2	1.4
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	4 422.2	6 814.3	4.1	6.2
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	4 131.3	6 159.0	3.9	5.6
Ус хуримтлуулах, ариутгах, усан хангамжийн үйл ажиллагаа	290.8	655.2	0.3	0.6
Дүн	106 622.5	109 066.4	100.0	100.0



II.5.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, ОНЫ ҮНЭЭР, САЯ.ТӨГ

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	2014.X	2015.X	2014.I-X	2015.I-X	$\frac{2015.I-X}{2014.I-X} \%$
Уул уурхай, олборлох аж үйлдвэр					
Хүрэн нүүрс	153.6	181.0	902.8	2 547.5	2.8*
Цайрын баяжмал	3 662.8	4 191.5	41 998.3	45 588.8	108.5
Хайрга	17.4	-	543.7	110.8	20.4
Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж					
Дулааны эрчим хүч	357.8	708.0	2 288.7	3 713.1	162.2
Түгээсэн цэвэр ус	27.9	70.5	290.8	496.5	170.7
Цахилгаан	0.0	0.0	0.0	0.0	-
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа, ус үйлдвэрлэл					
Аарц	-	-	2.0	1.0	48.9
Бялуу	3.5	5.3	28.1	39.0	138.8
Зайрмаг	0.4	-	85.3	56.4	66.1
Нарийн боов	21.4	22.6	133.1	147.5	110.8
Талх	67.2	73.9	493.4	570.8	115.7
Тараг	-	-	8.2	8.4	102.0
Хиамны зүйл	0.6	-	14.2	8.8	61.7
Хийжүүлсэн цэвэр ус, рашаан	3.1	4.6	20.6	46.5	225.7
Хэвийн боов	13.5	5.3	70.9	70.9	100.0
Хэрчсэн гурил	-	0.1	18.8	3.8	20.2
Цөцгий	-	-	-	0.4	-
Хувцас үйлдвэрлэл					
Ажлын хувцас	0.5	0.2	2.0	2.7	135.0
Гар хийцийн оёмол эдлэл	-	-	0.0	0.0	-
/Хөөрөгний дайлин г.м/	-	-	-	-	-
Гэрийн бүрээс	-	0.6	-	1.3	-
Дээлнээс бусад монгол хувцас	0.1	0.1	9.4	11.8	125.5
Монгол гутал	-	0.7	2.4	6.4	2.7*
Монгол дээл,тэрлэг	11.2	7.0	169.9	148.5	87.4
Оёмол пальто	-	-	-	0.1	-
Оёмол хүрэм	-	0.0	1.5	1.8	123.4
Өмд	-	1.2	2.1	1.7	81.7
Туурга	4.5	2.5	18.9	19.2	101.6
Хүүхдийн платые	-	-	0.0	-	-
Эмэгтэй хослол	-	-	0.3	-	-
Юбка	-	-	0.2	-	-
Модон эдлэл					
Бүх төрлийн чавхдаст хөгжмийн зэй -	-	-	-	0.8	-
Гал тогооны өрөөний модон тавилга	2.4	1.4	16.1	10.1	62.7
Гар урлал, сийлбэрийн зүйлс	-	-	1.0	-	-
Гэрийн бусад модон тавилга	0.9	0.4	4.9	2.7	55.1
Модон сандал	0.1	0.1	1.8	0.9	48.1
Төрөл бүрийн модон эдлэл	1.0	2.1	11.7	7.3	62.4
Төмөр эдлэл үйлдвэрлэл					
Гал зуух, хоолны төмөр эдлэл	3.4	3.6	19.3	17.7	91.7
Гэр ахуйн төмөр эдлэл	0.9	0.1	5.5	2.1	38.2
Ширмэн болон төмөр зуух, яндан	3.2	2.0	6.7	4.8	71.6
Барилгын бүтээгдэхүүн					
Бетон зуурмаг	104.2	11.0	804.5	45.2	5.6
Замын хавтан, хашлага	2.3	-	38.3	7.0	18.3
Таваарын бетон	1.7	-	58.1	3.6	6.1
Улаан тоосго	-	-	661.2	56.8	8.6
Хүрмэн блок	72.4	27.6	713.4	605.8	84.9
Бусад үйлдвэрлэл					
Ариун цэврийн цаас	0.4	0.0	3.5	0.6	18.3
Сувагжуулалт	13.6	20.8	132.1	158.8	120.2
Эсгий	-	4.5	11.6	12	103.4



II.5.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, төрлөөр

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2014.X	2015.X	2014.I-X	2015.I-X	$\frac{2015.I-X}{2014.I-X} \%$
Уул уурхай, олборлох аж үйлдвэр						
Хүрэн нүүрс	мян.тн	8.0	7.6	38.6	82.3	213.2
Цайрын баяжмал	мян.тн	6.4	6.9	77.6	75.2	96.9
Хайрга	мян.мЗ	0.6	-	17.2	3.8	22.1
Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж						
Дулааны эрчим хүч	мян.Гкал	7.8	9.4	57.3	63.4	110.6
Түгээсэн цэвэр ус	мян.мЗ	12.9	22.5	151.1	169.0	111.8
Цахилгаан	сая.квт	2.1	2.1	18.4	20.4	110.9
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа, ус үйлдвэрлэл						
Аарц	тн	-	-	1.0	0.4	40.0
Бялуу	тн	0.3	0.4	1.9	3.5	184.2
Зайрмаг	мян.ш	1.0	-	259.1	142.5	55.0
Нарийн боов	тн	7.3	6.4	47.1	42.6	90.4
Талх	тн	55.6	53.6	434.9	428.2	98.5
Тараг	мян.л	-	0.4	-	3.8	-
Хиамны зүйл	тн	0.1	-	2.3	1.3	56.5
Хийжүүлсэн цэвэр ус, рашаан	мян.л	17.0	25.6	113.3	254.9	225.0
Хэвийн боов	тн	3.4	1.3	17.5	18.4	105.1
Хэрчсэн гурил	тн	-	-	9.4	1.5	16.0
Цөцгий	тн	-	-	-	0.1	-
Хувцас үйлдвэрлэл						
Ажлын хувцас	ш	16	3	36	53	147.2
Гар хийцийн оёмол эдлэл		-	-	12.0	16.0	133.3
/Хөөрөгний дайлин г.м/	мян.төг	-	-	-	-	-
Гэрийн бүрээс	ш	-	7	-	14	-
Дээлнээс бусад монгол хувцас	ш	6	3	314	355	113.1
Монгол гутал	хос	-	17	69	153	221.7
Монгол дээл,тэрлэг	ш	186	115	3 220	2 579	80.1
Оёмол пальто	ш	-	-	-	1	-
Оёмол хүрэм	ш	-	1	46	38	82.6
Өмд	ш	-	18	68	25	36.8
Туурга	ш	19	8	92	70	76.1
Хүүхдийн платье	ш	-	-	1	-	-
Эмэгтэй хослол	ш	-	-	8	-	-
Юбка	ш	-	-	3	-	-
Модон эдлэл						
Бүх төрлийн чавхдаст хөгжмийн зэмсэг	ш	-	-	-	4	-
Гал тогооны өрөөний модон тавилга	ш	2	2	15	9	60.0
Гар урлал, сийлбэрийн зүйлс	ш	-	-	5	-	-
Гэрийн бусад модон тавилга	ш	2	1	26	14	53.8
Модон сандал	ш	12	7	224	99	44.2
Төрөл бүрийн модон эдлэл	мян.төг	1 000.0	2 080.0	11 730.0	7 250.0	61.8
Төмөр эдлэл үйлдвэрлэл						
Гал зуух, хоолны төмөр эдлэл	мян.төг	3 370.0	3 579.0	19 339.0	15 709.0	81.2
Гэр ахуйн төмөр эдлэл	ш	49	2	404	139	34.4
Ширмэн болон төмөр зуух, яндан	ш	36	13	63	29	46.0
Барилгын бүтээгдэхүүн						
Бетон зуурмаг	мЗ	546.3	68.5	4 664.6	269.5	5.8
Замын хавтан, хашлага	м2	165.0	-	3 517.1	451.6	12.8
Таваарын бетон	мЗ	3.2	-	160.0	16.6	10.4
Улаан тоосго	мян.ш	-	-	2 336.4	184.5	7.9
Хүрмэн блок	мян.ш	60.0	23.0	617.2	495.0	80.2
Бусад үйлдвэрлэл						
Ариун цэврийн цаас	мян.ш	1.0	-	10.0	1.0	10.0
Сувагжуулалт	мян.мЗ	9.4	11.8	100.6	88.8	88.3
Эсгий	мян.м	-	0.7	1.5	1.7	113.3



Хаяг: Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум
Аймгийн нутгийн удирдлагын ордон, 102, 103 тоот
Вэб сайт: <http://sukhbaatar.nso.mn>
Фесбүүк хуудас: <https://www.facebook.com/statistic>
Холбоо барих утас: 70518819, 70518203
И-мэйл: sukhbaatar@nso.mn, statistic_suh@yahoo.com

Үндэсний Статистикийн хорооны мэдээллийн сайт: <http://www.nso.mn>
Статистик мэдээллийн нэгдсэн сангийн сайт: <http://www.1212.mn>
Тооллогын мэдээллийн сангийн сайт: <http://arcgis.nso.mn>
Аймгийн мэдээллийн сайт: <http://sukhbaatar.mn>

СТАТИСТИК -
ХӨГЖИЛД ХӨТЛӨГЧ ХҮЧ